



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 5779-ТАГ-БААТААГ-2018-01-17 Номгон

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Баянхонгор төмөрт” ХХК төмөр хашаа, хайс үйлдвэрлэхээр 62,0 сая төгрөгийн зээл авч, 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс үйл ажиллагааг эхлүүлэхээр гэрээнд заасан байхад үйл ажиллагаа эхлэх шатандаа явж байгаа, төсөлд заасан тоног төхөөрөмжийг аваагүй, ажлын байрыг бариагүй байна.

Энэ нь “Баянхонгор төмөрт” ХХК-ийн “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мөнхбаттай байгуулсан ХОЗГ-2017/12/01 тоот гэрээний 3.1.2-т заасан “Хавсралт 2-д заасан цаг хугацааны графикт заасан хугацаанд төслөө хэрэгжүүлээгүй нь нэг талын санаачлагаар гэрээг цуцлах үндэслэл болно”, 5.2.1-т заасан “зээлдэгч нь санхүүжилтээ авснаас хойш Хавсралт 2-д заасан цаг хугацаанд төслөө хэрэгжүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь “Байгуулсан гэрээ, хэлцэл, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийг хангаагүй”, 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор төсөлд заасан тоног төхөөрөмжийг худалдан авч, үйл ажиллагааг жигдрүүлэх
2. Албан шаардлагын биелэлтийг 2018.07.05-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгалмаа, "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Батцэрэн, ахлах мэргэжилтэн Р.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Б.ДОЛЖМАА
Б.АЗБАЯР

ЗЭВШӨӨРСӨН:

ДАРГА

С.БАЙГАЛМАА

"БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ ХӨГЖЛИЙН
КОРПОРАЦИ" ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

С.БАТЦЭРЭН

Р.НАРАНЦЭЦЭГ

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрзэт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна" гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хургуулна.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 6/80/ГАГ-БНАТАГ-1/2018/-01-11 Номгон

Г Зөрчил арилгуулах тухай Г

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумдын багийн эмч, хэсгийн төлөөлөгч наарт мотоцикл авч өгөх зардалд 34,0 сая төгрөг баталж, нийтдээ 20 ширхэг мотоцикл авснаас 19 мотоциклийг багийн эмч, хэсгийн төлөөлөгч наарт олгож, 1 мотоциклийг Бөмбөгөр сумын байгаль хамгаадах иргэдийн бүлэгт олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй”, 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 1700,0 мянган төгрөгийн үнэ бүхий мотоциклийг Бөмбөгөр сумын ЗДТГ-т бүртгэх

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.06.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Бөмбөгөр сумын ЗДТГ-ын дарга Б.Чулуундорж, нягтлан бодогч Ж.Гандалай нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР АУДИТОР	ӨГСӨН:  Б.ДОЛЖМАА Б.АЗБАЯР	ЗӨВШӨӨРСӨН:  Б.ЧУЛУУНДОРЖ Ж.ГАНДАЛАЙ
БӨМБӨГӨР СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА НЯГТЛАН БОДОГЧ		
ВИА0001 9008196		

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 781/ТАТ-БНАТАТ-1208/-0117 Номгон

Г Зөрчил арилгуулах тухай Г

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:


Аймгийн Прокурорын газрын дээврийн засварын ажилд 31500,0 мянган төгрөг батлагдаж, аймгийн Засаг дарга Зэвсэгт хүчний 339 дүгээр ангитай 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр 31021,2 мянган төгрөгийн гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгэсэн байхад байгуулагын санхүүгийн тайланд их засварын ажлыг 31500,0 мянган төгрөгөөр буюу 478,8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Няглан бodoх бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, няглан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Няглан бodoх бүртгэлийг Няглан бodoх бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй”, 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй

байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Орон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн барилгын дээврийн засварын ажлын капиталжуулсан дүнг санхүүгийн тайланд 478,8 мянган төгрөгөөр бууруулж бүртгэх
 2. Албан шаардлагын биелэлтийг 2018.06.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Прокурорын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Ч.Бодьбямба нарт хариуцуулав.

<p>АХЛАХ АУДИТОР</p> <p>АУДИТОР</p>	 <p>Б.ДОЛЖМАА Б.АЗБАЯР</p>
<p>6417140544 ВНОА0067 0007423</p> <p>ЗЭВШӨӨРСӨН:</p> <p></p>	

АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН

ДАРГА НЯГЛАН БОДОГЧ *Д.Бат-Эрдэнэ*
Ч.БОДЬЯМБА

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлэсэйг тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.